

ҮЕ ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ОНОГДУУЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

HISTORICAL TRADITION OF SENTENCES OF COMMUNITY SERVICE IN CRIMINAL LAW



Ч.Нансалмаа

*ДХИС-ийн Удирдлагын академийн 8013 дугаар
дамжааны суралцагч, ахлах дэслэгч*

Судалгааны ажлын товч утга:

Монгол улсад эрүүгийн хариуцлагын тогтолцоо хууль эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгалаа олж, нийгэмд хор уршигтай ямар үйлдэл эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож, ялтанд оногдуулж байсан ялын төрлүүд үүнээс тэр тусмаа одоогийн эрүүгийн хуулийн ялын нэг төрөл болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулж ирсэн түүхэн уламжлалыг судалж, цаашид хэрхэн уг ял эдлүүлэх ажиллагааны хяналтын үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах, ялын үр нөлөө, ач холбогдолыг дээшлүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Abstract: How the system of criminal responsibility in Mongolia is reflected in the legal documents, the types of punishments given to convicts are considered crimes, and the types of punishments given to convicts, especially the historical tradition of community service, which is a type of punishment in the current criminal law. , how to further improve the system of supervision of the sentencing process, and to determine ways to improve the effectiveness and significance of the sentence.

Түлхүүр үгс: ял шийтгэл, эрх зүйн баримт бичиг, ялын үзэл баримтлал

Key words: sentence, legal documents, and sentencing concepts

ОРШИЛ

Төр эрх зүйн түүхэн уламжлалын арвин их түүхтэй манай улсын хувьд олон улсын болон өнөөгийн нийгмийн өөрчлөлт хувьслын цаг үетэй хөл нийлүүлэн хууль эрх зүйн орчныг шинэчлэн хуулийн хариуцлага

хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхдээ ял завшуулахгүй байх, хүний эрхийг зөрчихгүй ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь зүйтэй юм.

Бусдын эрх ашгийг хөндсөн бус үйлдэл, эс үйлдэхгүйг тодорхойлж, хариуцлага тооцож, шийтгэдэг тогтолцоо түүхэн цаг үе бүрд байсаар ирсэн. Хүннхү улсын хэв хуулиас өнөөгийн мөрдөгдөж байгаа эрүүгийн хуульд заасан хориглосон үйлдэл, эс үйлдэхгүй бүрд хуульд заасан ял оногдуулж байгаа нь нөгөөтэйгүүр шударга ёсны зарчимд нийцэхүйц бодлого юм. Эрүүгийн хуулийн шинэчлэн найруулсан 2002 оны эрүүгийн хуульд шинэ нэршлээр тусгагдсан “Нийтэд тустай ажил хийлгэх ял” нь гагцхүү гэмт хэрэгтнийг цээрлүүлэхээс гадна нийгэмд үр ашигтай үр дүн өгөхүйц ялын санхүү байснаараа ач холбогдолтой.

Монгол улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн явцад хэрхэн уламжлагдаж, шинэчлэгдэж ирсэн түүхийн хуудсыг судалж, үе үеийн эрүүгийн хариуцлага, тэр тусмаа нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрхэн хэрэгжүүлж байсан түүхийн баримтаас давуу болон сул талыг тусгахын зэрэгцээ онцлогийг илэрхийлж, ялын бодлогын үзэл баримтлал, хандлагыг судлахыг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Түүхийн эх сурвалжаас үзэхэд хүмүүсийн хамтын ажиллагаа, хамтдаа баялаг бүтээх, амьдралын хэв маягт зайлшгүй хэрэглэгдэх хэрэгцээний эд үйлийг бий болгох зэрэг үйл ажиллагаа үүссэн цаг үеэс улс орны нийгмийн байгуулал бий болсон гэж үзэхээр байна. МЭӨ IV зууны үед үүсэн бүрдсэн Хүннүгийн холбоо нь төв ба Дундад ази дахь анхны томоохон төрийн бүрдлийг бий болгосон. Өөрөөр хэлбэл Хүннүгийн үеэс овог аймгууд Улсын захиргаа цэргийн хуваарь болох Түмтийн хуваарьт оруулсан¹ нь төрт улсын шинжийг агуулсан тогтолцоо юм. Төрт ёсны тогтолцоо нэгэнт бий болсонтой холбоотой овог аймгийнхаа нийгмийн олон төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Дэлхий дахины хүн төрлөхтний түүхэнд гол төлөв төрд тэрсэлсэн, хүний амьд биед халдсан (алсан, гэмтээсэн), эд хөрөнгөд халдаж хулгайлсан, дээрэмдсэн, байгаль орчинд хор хохирол учруулсан шинжтэй байсан² талаар Энэтхэгийн “Ману”-гийн хууль, “Хаммурапи хаан”-ы

¹ Ж.Болдбаатар, Д.Түндээжанцан, Монгол улс төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997 он, 13 дахь тал

² С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. Уб., 2014. 9 дэхь тал

хуульд тусгасан байдаг. Нийгмийн харилцаа өргөжихийн хэрээр хүмүүсийн сэтгэлгээ хандлага өөрчлөгдснөөр нийгэмд эмх замбараагүй байдал үүссэнээр төрийн зохицуулах асуудал ч олширч, зөрчигдсөн эрхийг хамгаалах, гэмт үйлдэл үйлдэгчид хариуцлага тооцох, цээрлүүлэх зорилгоор ял шийтгэл үүссэн.

МЭӨ III зууны үеэс нийтэд тустай ажил хийлгэх ялын мөн чанарыг агуулсан ял шийтгэлийн төрөл хэрэгжиж байсан нь түүхэнд дэлгэрэнгүй бус хэдий ч түүхэн эх сурвалжид хэрхэн авч үзсэнийг мөлжигч нийгэм, Феодалын нийгэм, Ноёлогч анги, Капиталист нийгмийн үед гэмт хэрэгт тооцдог байсан үйлдэл эс үйлдэхүйг харьцуулан судлахад бүхий л цаг үед эд хөрөнгийн харилцаа, гэр бүлээс гадуурх харилцаа, хаад ноёдын эсрэг үйл хэргийг үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулдаг байсан байна.

Тухайн цаг үеийн хууль эрх зүйн үзэл баримтлалыг тухайлан авч үзвэл:

Мөлжигч нийгэмд гэмт хэрэгтэй тэмцэх гол арга нь эрүүгийн ялын бодлого байв. Тухайн үед ноёлогч ангийн хэмжээгүй эрхэт байдал, дарлагдсан ангийн бүлэг хэсгүүдийн хоорондын зөрчилдөөн, гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг бий болгож байв. Хуулийн агуулга төрийн эрх мэдэл, халдашгүй байдал, хүний амь нас, бие махбодь, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд байсан бол цаазлах, эрхтнээс хагацуулах, бие мах бодийг зовоох, тарчлаах, эд хөрөнгийг хураах, хүнд хөдөлмөрт зүтгүүлэх, хөөн зайлуулах, гутаах¹ зэрэг ялын төрлийг ашигладаг.

Боолын нийгэмд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд боол болгох ял шийтгэж, хүнд хөдөлмөрт зүтгүүлж, байсан нь одоогийн нийтэд тустай ажил хийлгэх ялын утгыг агуулсан ял юм.

Феодалын нийгэм, ноёлогч ангийн үед гэмт хэрэгтнийг өөрсдөдөө ашигтайгаар хөлсгүй хөдөлмөр хийлгэх замаар материаллаг ашиг олох бодлого баримтлаж байсны үндсэн зорилго бол эд эрхтэнийг хөдөлмөр эрхлэх явцад бэртээн ноёлогч бүлгийн эсрэг тэрслэн бослого үймээн гаргах боломжгүй болгох явдал байв². Түүхийн баримтаас үзвэл эрүүгийн хариуцлага буюу ял шийтгэлийн бодлого харгис хэрцгий, ялын зорилго нийгмийн үзэл баримтлалаараа хаад ноёд, ноёлогч бүлгийн эрх ашгийг хамгаалсан чиг хандлагатай байсан байна. Харин эртний болон дунд үеийн гүн ухаантнууд, соён гэгээрүүлэгч нарын ял шийтгэлийн зүй бус бодлогыг

¹ С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. УБ., 2014. 11 дэхь тал

² Мөн тэнд 13 дахь тал

эсэргүүцэж, харгис хэрцгий ял шийтгэлийн бодлого нь гэмт хэрэгтэй тэмцэх бус харин ч улам хүний ёс суртахууныг доройтуулдаг тул энрэнгүй ёсны зарчмыг чл шийтгэлийн бодлогод баримтлах нь зүй ёсны юм гэх номлолыг бий болгосон гүн ухаантан бол Аристотель, Платон нар юм. Феодлын нийгмийн задралын дараагаар ноёлогч анги хүмүүсийн аж амьдралыг улам доройтуулж, аль болох ял оногдуулж, тэднийг хүнд хөдөлмөрт зүтгүүлж өөрсдийн эрх ашгийг хамгаалсаар байв. Гэвч энэ нь цаг үеийн өөрчлөлт хөгжлийн явцад зайлшгүй үүссэн ниймгийн олон төрлийн харилцааг зохицуулахын хажуугаар эрх баригч нарт бэрхшээл үүсгэх болсон бөгөөд ниймгийн амьдралын хөгжлийн өөрчлөлтийн үед хорих ялын үр нөлөөний сөрөг үр дагаврыг ойлгон, ялын бодлогыг зөөлрүүлэх нь гэмт хэргийг багасгах үр дүнд хүргэх боломжтой гэж үзсэн нь дэлхий дахинд хорихоос өөр төрлийн ялын бодлого бий болгожээ.

Монгол эртний улсуудын хэв болон бичмэл хуульд дурдснаар тухайн үеийн нийгмийн харилцаанд тулгурласан эрүүгийн ялын бодлого байсаар ирсэн. Дээр дурдсанчлан Хүннү улсын үеэс төрийн байгуулал бий болсонтой холбоотой ял шийтгэлийн төрөл нь цаазаар авах, хорих (үйлдвэр урлалд зүтгүүлэх), өмч болон гэр бүлийг хураах, бэрээдэх, **хүнд ажилд зүтгүүлэх** зэрэг байв.

Их Монгол улсын бутралын үеийн эрх зүйн гол эх сурвалж болох “Алтан хааны цааж бичиг”, “Арван номын цагаан цааз”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Их засаг хууль”, “Монгол-Ойрдын хууль”, “Юан улсын нэвтэрхий толь” зэрэг хуулиудад **“үйлтгүүлэх ял буюу биеийн хүчний хүнд хүчир ажил хийлгэх”** гэх нэршилтэйгээр тусгагдсан байдаг¹.

Манжийн үеийн “Манж чин улсын хууль”, “Халх журам”, “Монгол цаазын бичиг” гэсэн гол гурван хуулиудад гэмт хэрэг үйлдсэн хүмүүст цаазаар авах, ташуурдах, цөлөх, хорих, хэргэм зэрэг эвдэх, торгох, хөрөнгө хураах, боол болгох, **түлээ түүлгэж ус дамнуулах**² зэрэг ял шийтгэлийн төрөлтэй байжээ. Монгол цаазын бичигт ялыг дотор нь үндсэн болон нэмэгдэл ял гэж ангилах ойлголт анх бий болгосон онцлогтой бөгөөд албадан ажил хийлгэх ялыг анх нэмэгдэл болон үндсэн ялаар оногдуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг байна³.

¹ С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016. 13 дахь тал

² С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016. 14 дэх тал

³ С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. Уб., 2014. 60 дэхь тал

Богд хаант Монгол улсын үе буюу 1921 оны үед төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг түшмэд, шашин номын зүтгэлтэнгүүд өмнөх түүхэн цаг үед хэрэглэж байсан ял шийтгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, эрүүгийн хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгож Олноо өргөгдсөн Богд хааны зарилгаар тогтоосон “Монгол улсын хууль зүйн бичгийн 65 дэвтэр эмхтгэлд зургаан сараас хоёр жилийн хугацаагаар **“үйлтгэх” буюу “албадан ажил хийлгэх”** ялыг оногдуулдаг байсан нь түүхийн хуудаснаа хууль цаазын чухал үйл явдал болсон тухай эх сурвалжийг С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээлийнхээ ишлэлд дурджээ.

Ардын хувьсгал өрнөсөн 1921 онд эрх зүйн шинэ эрин ирсэнтэй холбоотой 1921 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр “Тангарагийн гэрээ”-г Ардын засгийн газар, Богд хаан хоёрын эрхлэх үйл ажиллагааны ялгаа заагийг тогтоосноор эрүүгийн эрх зүйтэй холбоотой асуудал засгийн газрын мэдэлд шилжиж, эрүүгийн эрх зүйн хуучин хууль цаазыг хүчингүй болгож, “Ардын засгийн газрын хурлаас гаргасан хуульчилсан акт” (хурлын тогтоол), “Улс төрд онц ноцтой хэргийг таслуулахаар засгийн газраас байгуулсан комиссын тогтоол” гэх хэлбэрээр эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг шинэчлэн гаргасан. Хувьсгалыг ялалтын үр нөлөөгөөр нийгмийн харилцаанд гарсан эрс өөрчлөлтүүдийн үр нөлөөнд гадаад улсын иргэдтэй холбоотой маргаан, зөрчлүүд үүсэх болсонтой холбоотой эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хууль тогтоомжинд олон улсын хууль дүрмийг судлан, тусгах, мөн дотоодын эрх ашгийг хамгаалах үндсэн хуультай болох шаардлага үүссэн. Түүхэн цаг үеийн эрүүгийн ял шийтгэлийн төрөлд одоогийн нийтэд тустай ажил хийлгэх ялын нэршил, оногдуулж ирсэн түүхэн уламжлалыг системчлэн дурдвал:

Хүснэгт 1.

№	Түүхэн цаг үе	Эрх зүйн баримт бичиг	Ялын нэршил
1	Хүннү улс (IV зууны үе)	Зан заншлын ёс горимууд, бичигдмэл бус, заншлын хэм хэмжээ, Түүхийн тэмдэглэл	хүнд ажилд зүтгүүлэх
2	Их Монгол улсын бутралын үе (XII зууны эх)	“Алтан хааны цааж бичиг”, “Арван номын цагаан цааз”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Монгол-Ойрдын хууль”, “Юан улсын нэвтэрхий толь”	үйлтгүүлэх ял


3	Манжийн үе	“Манж чин улсын хууль”, “Халх журам”, “Монгол цаазын бичиг”	түлээ түүлгэж ус дамнуулах
4	Богд хаант Монгол улсын үе (1911 он)	“Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”	“үйлтгэх” буюу “албадан ажил хийлгэх”
5	Шинэ үндсэн хууль батлагдаж, ардчилал бий болсон цаг үеэс хойш	1926 оны шүүх цаазын бичиг	100 өдрөөс хэтрэхгүй хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
6		1929 оны шүүх цаазын бичиг	Хорихгүйгээр албадан ажил, үйлдвэр хийлгэх
7		1931 оны Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль	Хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг гүйцэтгэх
8		1934 оны шүүх цаазын бичиг	Албадан ажил хийлгэх
9		1942 оны эрүүгийн хууль	Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх
10		1947 оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
11		1961 оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
12		1986 оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
13		1996 оны эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
14		2002	Албадан ажил хийлгэх
15		2015	Нийтэд тустай ажил хийлгэх
16		2017 оны нэмэлт өөрчлөлт	Нийтэд тустай ажил хийлгэх

Одоогийн мөрдөгдөж байгаа эрүүгийн хуульд заасан нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтанд зохион байгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162, 163, 164, 165, 166 дугаар зүйлүүдэд заасны дагуу зохион байгуулахаар хуульчилсан.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны сүүлийн гурван жилийн байдлаар

Хүснэгт 1. нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоон мэдээ¹

¹ (<https://www.ncs.cd.gov.mn/>, 2024



Тоон мэдээнээс дүгнэвэл нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтны тоо 2021 онд 19.1 хувь, 2022 онд 25.9 хувиар тус тус жил бүр өссөн дүнтэй байна

Иймээс хорихоос өөр төрлийн ялын энэ төрлийг хэрхэн үр ашигтай зохион байгуулах нь олон талын нийгэмд эерэг үр дагаврыг бий болгож, ял эдлүүлэх ажиллагааны мөн чанарыг алдагдуулахгүй зохион байгуулахын тулд нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүсээд байна.

ДҮГНЭЛТ

Аливаа улс орон оршин тогтнох үндэс суурь нь төрийн бодлогын үзэл баримтлал улс орны сайн сайхны төлөө төлөвлөгдсөн, зарчимтай байхаас гадна дэлхийн хөгжлийн чиг хандлагыг даган цаг үетэйгээ хөл нийцүүлэн хувьсан өөрчлөгдөх чадвартай байх юм.

Эртний улсын эрх зүйн үндсэн шинжид гэмт хэрэг хэмээн тооцдог үйлдэл эс үйлдэхүй, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны зорилго ялтныг тарчлаах, хаад, ноёд өөрсдийн эрх ашгийн төлөө үнэ хөлсгүй хөдөлмөрлүүлж байсан нь одоогийн нийтэд тустай ажил хийх ялын зорилгын эсрэг үзэл баримтлалыг агуулж байсан байна. Мөн дахин гэмт хэрэг үйлдэх, ноёлогч ангийн эсрэг тэмцэл үймээн гаргуулахгүй байх зорилгоор хүнд хүчир ажил хийлгэж байх хугацаанд нь эд эрхтнийг нь гэмтээх бодлого баримталж байсан тухай түүхийн эх сурвалжид дурдсан байна. Монгол улс төр эрх зүйн түүхэн хөржлийн явцад ард иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалахаас гадна нийгэмд гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг судалж, гэмт үйлдлээс иргэдийнхээ эрхийг хамгаалах чадвартай хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хянаж, гэм

буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх бодлого түүхэн үе бүрд нийгмийн хувьсан өөрчлөлт, дэлхий нийтийн чиг хандлагыг даган тухай бүр өөрчлөн шинэчлэгдэж чадаж байсан нь өнөөгийн эрүүгийн хариуцлагын тогтолцоо бүрэлдэн тогтнох үндэс болжээ.

Төв азийн нүүдэлчдийн түүхийг өгүүлэх Хүннү улсаас МЭӨ 209 оноос Богд хаант Монгол улсын үе 1911 он хүртэл, Ардын хувьсгал ялж, Монгол улс тусгаар тогтносон бие даасан улс болж, үндсэн хуулиа тунхаглан батласан 1924 оноос одоогийн хэрэгжиж буй эрүүгийн хариулага хүлээлгэх ялын мөн чанар, зорилго, хэрэгжүүлэх арга зам харьцангуй дэвшилтэд замналыг туулан ирсэн гэж дүгнэж байна. Дээрх он цагийн ялын зорилгыг харьцуулахад хүний эрхийг хүндэтгэх, эрүүгийн хариуцлага хэн бүрд эрх тэгш үйлчлэх, ялын бодлогын үндсэн мөн чанар зэрэг олон асуудлууд харилцан адилгүй байгаа нь хөгжлийн явцад эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, гэмт явдалтай тэмцэх, эрх зүйн зохицууллатын үр нөлөөг өөрчлөлт шинэчлэлийн давалгаатай тодорхой цаг хугацаанд боловсруулах, зэрэг олон ач холбогдол бүхий харилцааг хөгжлийн чиг хандлагадаа шингээж чадсан байна гэж дүгнэж байна.

Мөн Хорихоос өөр төрлийн ялын үндэс суурь Хүннүд гэмт хэрэгтнийг бэрээдэх, хөрөнгийг хураах, хүнд хөдөлмөрт зүтгүүлэх, цаазаар авах шийтгэлийн дөрвөн төрөлтэй байсан¹ улсын үеэс эхлэлтэй бөгөөд эрх зүйн шинэтгэлийн явцад ялын зорилго өөрчлөгдөж, төрөл нэмэгдсэн.

Ардчилсан нийгэмд олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хүний эрхийг дээдлэх зорилгоор дотоодын эрүүгийн хуулийн ялын тогтолцоонд нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд хүнлэг, энрэнгүй байх, ял шийтгэл гарцаагүй байх цаашлаад улс орны эдийн засаг, ялтны хувийн байдлыг харгалзан үзэх нарийвчилсан эрх зүйн орчинг бүрдүүлж байгаагаараа онцлог хууль гэж үзлээ.

Монгол улсын ял шийтгэлийн бодлого нийгмээс тусгаарлаж хорих ял эдлүүлэхээс илүүтэй ялтныг нийгмийн орчинд гэмт хэрэг үйлдэхгүй байх хандлагыг төлөвшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх ёс суртахууныг төлөвшүүлэх зорилгыг агуулж нийтэд тустай ажил хийлгэх ялын төрлийг илүүд үзэж байгаа нь сүүлийн жилүүдэд ялтны тоо өссөн дүнтэй байгаа нь харуулж байна. Судалгааны ажлын нийтэд тустай ажил

¹ Ж.Болдбаатар, Д.Түндээжанцан, Монгол улс төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997 он, 19 дахь тал

хийлгэх ялын эрх зүйн зохиуцлалтыг сайжруулах боломжийг бий болгох үүднээс судлаачийн зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

➤ Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хувийн байдлыг дордуулж, нэг гэмт хэрэгт давхар хариуцлага хүлээлгэхгүй байх үүднээс тодорхой төрлийн эдийн засгийн бололжуудийг бий болгох

➤ Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэх байгууллагын жагсаалтыг шинэчлэн өөрчлөх

➤ Ялтны өөрийн амьдралын санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлдэг ажил хөдөлмөрөө алдахгүйгээр ял эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

➤ Ял эдлүүлж байгаа гэрээгээр үүрэг хүлээсэн байгууллагын

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Төрийн мэдээлэл, Т. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.
2. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
3. А.Алтанзул. (2007). Албадлагын арга хэмжээ, ял. Улаанбаатар.
4. Г.Г.Ф.Гегель. (n.d.). Фильсофия прова.

---o0o---